

ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Р.Алтанхундага

ДХИС-ийн Удирдлагын академийн 8012 дугаар дамжааны суралцагч, магистрант,
хошууч

Товч агуулга: Монгол Улсын хилийн боомт нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт, халдашгүй дархан байдлын илэрхийлэл, улс орны үүд хаалга, эдийн засаг, гадаад харилцааны стратегийн чухал ач холбогдолтой газар гэдэгт та бид эргэлзэх аргагүй билээ. Аливаа улсын хил дээр тодорхой нээлттэй гарцууд байх нь зайлшгүй ба зөвхөн энэхүү гарцаар дэлхийн улс орнуудтай харилцаж, зах зээлийн эдийн засгийн өрсөлдөөнд оролцох боломж бүрдэх юм. Хилийн боомтод нээлттэй, хурдан шуурхай үйлчилдэг байх зарчмыг баримтлан ажиллах хэдий ч улс орны аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний асуудал юм. Энэхүү илтгэлдээ улсын хилээр нэвтрэх тухай ойлголтын дэлгэрэнгүйгээр судалсан үр дүн, хилийн дэглэмийн болон хилийн боомтод мөрдөх журмын ойлголтууд, төгсгөлд хилийн боомтуудын өнөөгийн байдлын талаарх судалгааны үр дүнг танилцуулахыг зорилоо.

Түлхүүр үгс: хилийн боомт, хилийн дэглэм, хилийн боомтод мөрдөх журам, улс хил нэвтрэх.

Abstract: The border port of Mongolia stands as a testament to the nation's independence, sovereignty,

and economic vitality, serving as both a gateway and a strategic hub for foreign relations. Open gateways are indispensable for global interaction and economic competitiveness, facilitating communication with nations worldwide. While prioritizing swift border crossings, ensuring national security remains paramount. This report aims to present a comprehensive study encompassing the concepts of border crossing, border regime frameworks, procedural guidelines at border ports, and an evaluation of the current state of these ports.

Keywords: border crossing, border regime, border control procedures, border ports.

Хилийн боомт гэдгийг Монгол Улсын улсын хилийн шугамын дагуух хил орчмын нутаг дэвсгэрт, зам харилцаанд тулгуурлан байрлаж, тусгайлан тоноглож, төхөөрөмжилсөн газар, хуулиар олгогдсон эрх бүхий байгууллагууд улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд хяналт шалгалт хийх зорилготой газар гэж ойлгоно.

Манай улсад өнөөгийн мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүд, олон улсын зарим эрх зүйн баримт

бичгүүдэд хилийн боомтыг дараах байдлаар томьёолсон байна:

а. Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д “Хилийн боомт гэж улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг”¹;

б. “Хилийн боомт” болон “Боомт” нь адил утгатай байх бөгөөд Монгол, Хятадын хилийн 2 талд орших иргэд, тээврийн хэрэгсэл, бараа эд юмсад хяналт

шалгалт хийж, бүртгэн хилээр нэвтрүүлэх зориулалтаар тусгайлан тогтоосон газрыг хэлнэ”²;

в. Европын чуулган ба зөвлөлөөр 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан одоо Европын холбооны орнуудад мөрдөж буй “Хилийн тухай Шенгений тунхаглал” гэсэн баримт бичигт “Иргэд, тээврийн хэрэгсэл, объектуудад хилийн хяналт, шалгалт хийх, Европын холбооны улсуудын нутаг дэвсгэрт оруулах эсвэл орхин гаргах асуудлыг шийдвэрлэх тусгай талбай”-г хилийн боомт гэж үзнэ³.

Дээрх тодорхойлолтуудад дүгнэлт хийж үзвэл:

Хилийн боомт гэдэг нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, барааг нэвтрүүлэхээр тусгайлан тогтоож төхөөрөмжилсөн, хилийн хяналтын байгууллага хяналт, шалгалт явуулдаг газар (талбай) мөн байна.

Дээрх нэр томъёонуудын тодорхойлолтуудаас харахад тодорхой нэг буюу бүлэг субъектыг улсын хилээр нэвтрүүлэх үйлийг хэлж байна. Нэвтрүүлэх үйлийг хөрш улстай байгуулсан хэлэлцээрт зааснаар ямар нэгэн барилга байгуулж бүхий газар гэж, харин Европын холбооны улсын баримт бичигт тусгай талбай гэж нэрлэдэг байна.

Я.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д: “Газар”- Дэлхийн хуурай гадаргуугийн хөрс, шороо, “Талбай”- Хот суурин газар тусгай зориулалтаар хийгдсэн өргөн, тэгш талбар⁴ гэнэ.

А.Янжиндолгор, Н.Дашийн “Монгол хэлний тайлбар толь”-д “Газар”-Ямар нэгэн юмны тусгайлан заасан нэгэн хэсэг, тодорхой хэсэг⁵ гэнэ.

Харин орос хэлэнд “Пункт” гэсэн хилийн боомтын тухай тодорхойлолтод С.И. Ожегова “Орос хэлний тайлбар толь бичиг”-т:

¹ Монгол Улсын Хилийн тухай хууль, Төрийн мэдээлэл, Уб., 2017, №06, 152 дах тал.

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418>

³ Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээр, нэгдүгээр

зүйлийн нэгд.

<https://huhhot.consul.mn/subcategory/204>


⁴ “Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв” ХЗДХЯ-ны захиалгат судалгааны ажил, Уб., 2012.

⁵ <https://mongoltoli.mn/search.php>.

⁵ Янжиндолгор А., Даш Н., “Монгол хэлний тайлбар толь”. Уб., 2018, 256 дахь тал.

Пункт- ямар нэгэн зориулалтаар ашиглах байр¹ гэж тус тус тайлбарласан байна. Үүнээс харахад “газар, талбай” гэсэн үгийн хувьд харилцан адилгүй ялгаатай ойлгогдохоор байна. “Хилийн боомт” гэсэн тодорхойлолтыг жишээ болгох үүднээс автозамын хилийн боомтын ерөнхий бүдүүвчийг зураг 1-ээр үзүүлэв.

Зураг 1. Авто замын хилийн боомтын ерөнхий бүдүүвч



Улсын хилийг агаараар, төмөр замаар, авто замаар нэвтрэх харилцаа зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт заагдсан хилийн боомтод буюу энэ нь агаарын замаар олон улсын зэрэглэлтэй нисэх буудалд, төмөр замаар төмөр замын вокзал (өртөө), авто замаар олон улсын болон хоёр талын иргэд нэвтрэх хилийн боомтод явагдана.

Бүдүүвч зураг (зураг 1)-аас харахад хилийн боомт тодорхой хэсэг газрыг тусгайлан хязгаарлан заагласан, зорчигч, тээврийн хэрэгслийн урсгал хөдөлгөөний чиглэлээр нь ялгасан тэмдэг тэмдэглэгээ хийгдсэн, тухайн боомт руу орох, гарах хаалгатай, зорчигч, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх

шалгалтын талбайтай, хилийн хяналтын байгууллагуудын ажилтнуудын албаны байр объектууд, үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоногдсон (рентген төхөөрөмж, цацраг идэвхт бодис илрүүлэх төхөөрөмж, баталгаат агуулах гэх мэт), уурын зуух, цахилгаан хангамжийн дэд станц /бага оврын/, татваргүй барааны дэлгүүр, тээвэр зууч, арилжааны банкуудын байрлах байр, аюулгүй байдлыг хангах хяналт, дохиолол, инженерийн цогц байгууламж бүхий газар гэж ойлгож болохоор байна.


Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт явуулах эрх бүхий байгууллагуудыг хилийн тухай хуулийн 3.1.6-д заасан хилийн хяналтын байгууллага болох улсын хил хамгаалах, гааль, гадаадын иргэн, харьяатын байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж, хилийн боомт газар хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулна.

Улсын хил нэвтрэх гэдэг нь агаараар, төмөр замаар, автозамаар зорчигч, тээврийн хэрэгсэл, мал, амьтдыг А улсаас Б улс руу, эсвэл Б улсаас А улс руу улсын хилээр

¹ <https://gufo.me/dict/ozhegov>.

биетээр бодитоор явж өнгөрөх¹-ийг ойлгоно. Зураг 2-д үзүүлэв.

Зураг 2. Улсын хил нэвтрэх тухай ойлголт



Зорчигч, тээврийн хэрэгсэл ямар ч зам харилцаагаар, аль ч хилийн боомтоор улсын хилийг нэвтрэх тохиолдолд хилийн хяналт шалгалтаар заавал орох үүрэг хүлээнэ.

Зарим тохиолдолд хилийн боомт нь хилийн бодит шугамаас гүн тийш тодорхой зайтай байрлах тул боомтоор шалгагдаж гарсан зорчигч, тээврийн хэрэгслийг хилээр гарах хүртэл хил давсан гэж үзэх боломжгүй юм.

Улсын хилийг дараах байдлаар нэвтрэхийг зөвшөөрдөг байна. Үүнд:

- нээлттэй гарц буюу бүх улс орны иргэд чөлөөтэй харилцан нэвтрэх зөвшөөрөгдсөн хамгаалалтгүй гарц (европын зарим орнуудад);

- хил залгаа улсуудын хил орчмын ард иргэд хялбарчилсан журмаар нэвтрэх гарц (хоёр улс хоорондоо харилцан хэлэлцээр байгуулж, хялбарчилсан журмаар хэн, хэрхэн, ямар тохиолдолд, хаагуур, нэвтрэх эрхийн нутаг дэвсгэрийн харьяалал зэрэг тусгай журмыг зааж өгдөг);

- нээлттэй гарц буюу бүх улс орны иргэд чөлөөтэй харилцан нэвтрэх зөвшөөрөгдсөн цэрэг, цагдаагийн хамгаалалтад байх гарц юм.

Хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагааг Монгол Улсын олон улсын болон үндэсний хууль тогтоомжуудыг үндэслэн төрийн гүйцэтгэх засаглалын хилийн хяналтын байгууллага (хил хамгаалах, гааль, хилийн мэргэжлийн хяналт, гадаадын иргэн, харьяатын газар)-ууд хэрэгжүүлж байна. Эдгээр хилийн хяналтын байгууллагууд нь хилийн боомтод захиргааны албадлагын буюу тусгайлан тогтоосон “Дэглэм” сахиулах арга хэмжээ явуулдагаараа онцлог юм. “Дэглэм”-ийн тухай ойлголтыг тодорхойлж үзэхэд “Дэглэм” гэдэг нь “Монгол хэлний их тайлбар толь”-д журам, зарчим, хэв заншил, горим² гэж тайлбарлажээ.

“Улсын хил хамгаалалт”³ гэсэн тодорхойлолтоос харахад түүний үйл ажиллагааны нэг чиглэл нь хилийн болон хил орчмын дэглэм сахиулах арга хэмжээ юм.

Эдгээр хилийн болон хил орчмын дэглэм сахиулах арга хэмжээ нь хамрах хүрээ, зохиогдох арга хэмжээ, үйл явц өрнөх газар орон, түүнд үйлчлэх эрх зүйн орчин, зорилго, агуулга зэргээр өөр хоорондоо зарчмын ялгаатай байна.

“Монгол Улсын хилийн тухай хууль”-ийн арван хоёрдугаар зүйлд зааснаар: “Улсын хилийн дэглэмийн зорилго нь хил залгаа улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн асуудалтай

¹ “Нэвтрэх” гэдэг үгийн утга: Ямар нэгэн газраар явж өнгөрөх.
<https://mongoltoli.mn/search.php>.

² Монгол хэлний их тайлбар толь.,
<https://mongoltoli.mn/>.

³ Ганболд М. Хилийн нэр томъёоны тайлбар толь, УБ., 2010, 227 дахь тал.

холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахад оршино¹.

Харин улсын хилийн дэглэмийн агуулга нь "...улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, хил дамнасан байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, амьтныг хамгаалах журмаас" ² бүрдэж байна. Хуулийн эдгээр заалтууд нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай, түүхий эд бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхтэй холбогдсон буюу хилийн боомтод явагдах үйл ажиллагааг зохицуулж, тусгай журам гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх учиртай юм.

Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлж Улсын Их Хурал эрх олгосны дагуу Монгол Улсын Засгийн газар хил залгаа улстай байгуулсан гэрээгээр тогтоох талаар хуульчилжээ.

Мөнхийн хөрш улстай найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, өргөжүүлэн бэхжүүлэх, хилийн дэглэмийн гэрээнүүдийг биелүүлэх зорилгоор 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдөр ОХУ ³, 2004 оны 7 дугаар сарын 5-ны өдөр ⁴ БНХАУ-ын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг тус тус байгуулсан байна.

Харин улсын хил орчмын дэглэмийн зорилго нь "Монгол Улсын хилийн тухай хууль"-ийн хорин дөрөвдүгээр зүйлд "Улсын хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн дэглэмийг сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, улсын хил

хамгаалах үйл ажиллагаа явуулахад оршино"⁵ гэж тодорхойлсон нь хилийн дэглэм сахиулах ажиллагааны онолыг бодит практик хэрэглээнд баталгаажуулж байгаа бөгөөд эрх зүйн үндэс нь болсон байна.

Улсын хил орчмын дэглэмийн агуулга нь хуульд заасны дагуу хилийн бүс, зурвас, боомтод мөрдөх журмаас бүрдэнэ. Улсын хил орчмын дэглэмийн талаарх дээрх заалт ёсоор хилийн боомтод тодорхой журам тогтоохыг хуульчилсан эрх зүйн орчныг тодотгосон заалт болсон байна. Дээрх заалтыг улам нарийвчлан тодотгож хуулийн тусгай заалт болгон хилийн боомт гэж юуг хэлэх, түүнд мөрдөх журам тогтооход түүний агуулгад багтах арга хэмжээ, хориглох зүйлийн талаар уг хуульд нэг бүрчлэн зааж өгсөн байна.

Хилийн боомтын журмын эрх зүйн үйлчлэл нь зөвхөн хил нэвтэрч буй зорчигчдод төдийгүй энэхүү талбайд байж, хил нэвтрүүлэх ажил үйлчилгээнд холбогдож буй бүх хүнд хамаатай. Гэхдээ энэхүү дэглэмийн үйлчлэх хүрээ нь зөвхөн хил нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулж буй талбайгаар хязгаарлагдаж байдаг онцлогтой.

Хилийн боомтод үйлчлэх эдгээр дэглэмийг олон улсын гэрээ, конвенц, хоёр улсын хэлэлцээрээр тогтоож өгөх ба дэглэмийг сахиулах арга хэмжээг хилийн боомтод мөрдөх журмаар зохицуулна. Хилийн дэглэмийн асуудлыг өнөөгийн баримтлан мөрдөж буй хоёр талын хэлэлцээр ⁶-т тодорхой тогтоож өгсөн байдаг.

Үүнд:

Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр.

⁵ Монгол Улсын Хилийн тухай хууль, Төрийн мэдээлэл, Уб., 2017, №06, 161 дэх тал.

⁶ Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээр, 1, 2, 3, 4, 5, 7.

Хилийн боомт болон Монгол, Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай

¹ Монгол Улсын Хилийн тухай хууль, Төрийн мэдээлэл, Уб., 2017, №06, 160 дэх тал.

² Мөн тэнд

³ "Хилийн боомт болон Монгол-Оросын Улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай" Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр.

⁴ "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай" Монгол Улсын

-зорчигч, тээврийн хэрэгслийг аль хилийн боомтоор нэвтрэх;

-ямар тохиолдолд хил нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах;

-хилийн боомт бус газраар ямар тохиолдолд хил нэвтрэх болох эсэх,;

-хил орчмын ард иргэдийг ямар журмаар нэвтрүүлэх;

-хил нэвтрэх ямар баримт бичигтэй нэвтрэх;

-хил нэвтрэх эрхийн баримт бичгийг хэн, хаанаас, хэнд, ямар тохиолдолд олгох;

-авто тээврийн хэрэгслийн жолооч ямар үүрэг хүлээх;

-онцгой нөхцөл үүссэн үед ямар арга хэмжээг авах зэрэг дэглэмийн арга хэмжээнүүдийг хоёр тал харилцан хэлэлцэж тогтоож өгсөн байна. Үүнээс харахад уг баримт бичгээр тогтоосон дэглэм нь тунхаглалын шинжтэй боловч боомтод мөрдөх журмаар баталгаажуулж, үйл ажиллагаанд хэрэгждэг байна.

Боомтын дэглэмийг хилийн боомтод мөрдөх журмаар албажуулж баталгаажуулна. Харин дэглэмийн арга хэмжээг сахиулахыг хилийн хяналтын байгууллагууд шалгалтын горимоор зохицуулж өгнө.

Дэглэмийн арга хэмжээг сахиулахын тулд “Боомтод мөрдөх журам”-тай байх нь зайлшгүй юм. Өнөөгийн практик нөхцөлд үүнийг янз бүрийн байдлаар шийдвэрлэж ирсэн байна. Үүнд “Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журам” Монгол Улсын засгийн газрын 2003 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан №20 дугаар тогтоол, үүний дараахан 2013 онд батлагдсан “Хилийн боомтын тухай хууль” (хүчингүй болсон), 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хилийн тухай хууль” зэрэгт хилийн боомтод мөрдөх журмын

талаарх авч хэрэгжүүлэх арга хэмжээ, агуулгын хувьд бүгд ижил байжээ. Гэхдээ өмнөх хууль тогтоомжид заасан байдлаас ялгагдах зүйл нь 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Хилийн тухай хууль”-ийн 29.4.5 дугаар зүйлд заасны дагуу Хилийн боомтын үндэсний зөвлөлөөс батлан гаргасан “Хилийн боомтын нийтлэг журам” юм. Энэхүү журмаар хилийн боомтын хөгжил, барилга, байгууламж, дэд бүтэц зэрэг асуудлыг шийдвэрлэхээр зохицуулагдан хуульчилсан. Энэ утгаараа хилийн боомтын үйл ажиллагааг шууд утгаар нь зохион байгуулж, удирдах гэсэн үг биш харин үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, удирдах гэдэг утгаар нь ойлгох юм.

Мөн “Хилийн тухай хууль”-ийн 28.5, 28.6 дугаар зүйлд заасныг үндэслэн хилийн боомтод “Хилийн боомтод мөрдөх журам”-тай байна. Энэхүү журмыг уг хуулийн 29.8 дугаар зүйлд заасны дагуу “...тухайн хилийн боомтын зөвлөлийн дарга батална” гэж хуульчилсан. III.Арвай бүтээлдээ энэхүү асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлсэн байна. “Хилийн боомтод мөрдөх журмыг Монгол Улсын Засгийн газраас тогтоож байх нь цаашид илүү үр ашигтай, эрх зүйн үндэстэй байж болно”¹ гэжээ. Үүнээс үзэхэд хуулийг хэрэгжүүлэгч гүйцэтгэх засаглалын үүрэг оролцоо байх нь чухал гэсэн санаа юм болов уу гэж судлаачийн зүгээс үзэж байна. “Хилийн боомтод мөрдөх журам”-нь хилийн хяналтын байгууллагууд болон бусад үйлчилгээний байгууллагуудаас явуулах хяналт шалгалт, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны харилцааг зохицуулдаг. Хилийн боомтын төрөл, зэрэглэл, горим, нэвтрүүлэх хүчин чадал, хилийн хяналтын байгууллагуудын бүтэц, орон тооноос шалтгаалан хилийн боомтод

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, 1, 5, 6, 7, 10, 11, 12, 13 дугаар заалт.

¹ Арвай.Ш. “Улсын хилийн тухай” дурсамж, үзэл бодол, УБ., 2005, 201 дэх тал.

мөрдөх журмыг тухайн боомтын онцлогт тохируулж, хилийн хяналтын байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд хамтран боловсруулж, баталдаг.

Улсын хил нэвтрэх тухай асуудлын хүрээнд “Хууль бусаар улсын хил нэвтрэх” буюу хилийн зөрчлийн талаар авч үзье.

Хууль зүйн шинжлэх ухаанд “Дэ-юри”, “Де-факта” ойлголтын хүрээнд хил нэвтрэсэн, хил нэвтрэхийг завдсан гэсэн агуулгыг үйлдэл, эс үйлдэл гэдгээр тайлбарласан байдаг бөгөөд хууль, тогтоомжид энэ утгаар шууд хэрэглэнэ. Үүнийг түүхэн эх сурвалжид 1973 онд баталсан “БНМАУ-ын хил хамгаалах тухай хууль”¹-д тусгайлан зааж өгсөн байжээ. Тус хуулийн 24 дүгээр зүйлд дор дурдсан үйлдэл хийсэн этгээдийг БНМАУ-ын хил зөрчсөнд тооцно гэж анх хуульчилж өгсөн. Үүнд:

-Улсын хилийг тогтоосон боомтоос өөр газраар буюу тогтоосон боомтоор боловч хууль бус аргаар нэвтрэн гарсан, орсон, эсхүл тийнхүү хилээр нэвтрэн гарах буюу орохыг завдсан;

-БНМАУ-ын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр эсхүл тогтоосон агаарын замаар өөр чиглэлээр БНМАУ-ын хилийг нисэн давсан, нисэж ирсэн гэж² заасан байна. Үүнээс үзэхэд тухайн этгээдийн улсын хилийг хууль бусаар нэвтрэх буюу гарсан, орсон, нэвтрэхийг завдсан гэсэн үйлдлийг хуульчилж өгсөн байна.

Энэ талаар академич С.Нарангэрэл “...Монгол Улсын хилийг тухайн субъект нэвтрэсэн үеэс төгссөн гэмт хэрэгт тооцогдоно”³, хууль зүйн доктор, профессор С.Жанцан “...хууль

бусаар хил нэвтрэснээр гэмт хэрэг төгсөнө”⁴, хууль зүйн доктор Г.Совд асан “Хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт үйлдэл нь Монгол Улсын хилээр хууль бусаар орох, гарах, нэвтрэх үйлдэл хийж, хилийн дархан байдалд халдсанаар бүрдэл төгсдөг”⁵ гэж тус тус тодорхойлсонтой судлаачийн зүгээс санал нэг байна.

Иймд хилийн боомтын байгууламж бүхий цэгээр, төрийн тусгай албадын ил хяналтын дор хил нэвтрэх тохиолдолд хилийн шугамыг нэвтрэснээс бус, хил нэвтрэх эрх олгосон тэмдэглэгээг (орсон, гарсан тухай дардасыг) тухайн субъектэд хил нэвтрэх эрх олгож буй, зохих баримт бичиг дээр хийснээр, нэг үгээр хэлбэл субъектэд улсын хил нэвтрэх эрх нээгдсэнээр хууль бусаар улсын хил нэвтрэсэнд тооцох нь зүйтэй.

Харин хилийн боомтоор нэвтрэхээр шалган нэвтрүүлэх албаны зорчигчийн баримт бичгийг шалгах шалгагчид зорчигч хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээ шалгуулахаар өгч буй үйлдэл нь “хууль бусаар улсын хил нэвтрэх” гэмт хэрэг үйлдэхээр завдалт хийж буй эрсдэлт үйл мөн юм. Өөрөөр хэлбэл “орсон”, “гарсан” дардас дарж, хилээр нэвтрэсэн тухай тэмдэглэл хийгдээгүй байгаа хором юм. Энэ хоромд түүний үйлдэл “төгссөн” гэмт хэрэг эс тооцогдох бөгөөд, харин “завдалт” хэмээн үзэх эрх зүйн үндэс болно. Гэхдээ бодит нөхцөлд хилийн боомтоор хүчин төгөлдөр бус баримт бичгээр хил нэвтрэхийг завдаж буй этгээд нь санамсаргүй гэх тохиолдол хэзээ ч байж болохгүй асуудал юм. Энэ төрлийн гэмт хэрэг нь өөрөө санаатайгаар үйлдэх, эс үйлдэх хэв

¹ БНМАУ-ын хил хамгаалах тухай хууль, Уб., 1973.

² Доржняв .Ц. Улсын хил зөрчих гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага, криминологийн асуудал, Уб., 2012, 38 дахь тал.

³ Нарангэрэл.С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (тусгай анги), Уб., 1998, 45 дахь тал.

⁴ Жанцан. С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (тусгай анги, схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал), Уб., 2005, 2011, 31 дэх тал.

⁵ Совд. Г. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, Уб., 2002, 143 дахь тал.

шинжийг агуулж байгаа гэж ойлгож болох юм.

Дараагийн асуудал болох “Боомтод мөрдөх журам” зөрчих гэмт хэргийн шинжгүй зөрчил юм.

Хилийн тухай хуулийн 25, 26, 28 дугаар зүйлийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийг холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Эдгээр зөрчлийг “Зөрчлийн тухай хууль”-ийн 16 дугаар бүлэгт хариуцлагын асуудал болон гаргасан зөрчилд хэрхэн хариуцлага талаар тодорхой зааж өгсөн байдаг. Тухайлбал: Хил хамгаалах байгууллагын хувьд “Хилийн боомтод мөрдөх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хариуцах хуулийн зохицуулалттай байдаг. Үүний дагуу “Зөрчлийн тухай хууль”-ийн 16.1, 16.2, 16.3 дах заалтуудыг зөрчсөн тохиолдолд ямар зөрчлийн хэлбэрээр авч үзэх, зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээг зааж өгчээ. Дээрх хэлбэрийн зөрчлийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар “эрх бүхий албан тушаалтан” зөрчлийг шалган шийдвэрлэх учиртай юм. “Эрх бүхий албан тушаалтан”-д хилийн төлөөлөгч, орлогч, туслах нар хамаарах юм. Зөрчлийн хэлбэрийн хувьд дараах байдлаар гарч болох юм. Үүнд:

-Хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах зөрчил (хяналт шалгалтын дараалал зөрчих);

-хилийн боомтод мөрдөх журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчих гэсэн үндсэн 2 зөрчлийн хэлбэрүүд юм. Тухайн хилийн боомтод мөрдөх журамд хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрхэн зохицуулсан, хориглосон зүйлсийг хэрхэн зохицуулж журамд оруулсанаас

үүдэн зөрчлийн хэлбэрүүд хилийн боомт болгонд өөр өөр байх явдал байдаг байна.

Манай улс агаарын, төмөр замын, автозамын нийт 39 хилийн боомттойгоос Монгол, Оросын хилд 16 буюу 41 хувь, Монгол, Хятадын хилд 17 буюу 43 хувь, 6 буюу 15 хувь нь агаарын замын хилийн боомт байна.

Монгол-Оросын хил дээр 16¹ боомт ажиллахаас, түр буюу улирлын ажиллагаатай 9, дамжин өнгөрөх 6, бүгд 19 боомт нь (Асгатын гол-Аспайты, Бөхмөрөн-Кызыл-Хая, Харигийн гол-Мугур-Аксы, Тээл1-Торгалыг, Тээл 2-Хандгайт, Давст-Сарыг холь,Тэс-Сарыг холь, Баянзүрх-Тарисын рашаан, Шишгэд гол-Ушь-Бэлдир, Хээгт-Санага, Хонгор овоо-Бочий, Цагаан арал-Наушки, Хутаг-Өндөр-Киран, Хүдэр-Цагаан чулуутай, Тогтор-Өвөр тогтор, Ямалхын гол-Новый Дурулгуй, Бага-Илэнх-Айнек гол, Ээлтэр-Желтура, Агацын гол-Алтан) эдийн засгийн ач холбогдол багатай, дэд бүтэц бүрдээгүй, бүтээн байгуулалт хийгдээгүйгээс ажилладаггүй. Арцсуурь-Цагаантолгой, Ханх-Монд боомтуудыг олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомтын зэрэглэлээр ажиллуулах чиглэл баримталж байна.²

Монгол, Хятадын хил дээр 17³ боомтыг ажиллуулахаар тогтсон бөгөөд эдгээрээс Шивээхүрэн, Гашуунсухайт, Замын-Үүд, Бичигт боомтууд нь ажлын 7 хоногт, уртасгасан цагаар ажиллаж байгаа бөгөөд цаашид Булган, Бургастай, Ханги, Баянхошуу, Сүмбэр боомтуудыг уул уурхай, ашигт малтмалын тээвэрлэлт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын чиглэлээр хуваарийн бус үеэр байнга ажиллуулах талаар хоёр улсын Засгийн газар харилцан нот бичиг солилцож, зарчмын хувьд зөвшөөрсөн байна.

¹ “Хилийн боомт болон Монгол, Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хавсралт.

² ХХЕГ-ын Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх газрын тайлан, танилцуулга мэдээлэл, Уб., 2019.

³ Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн 2 дугаар зүйл.

Цаашид Монгол-Хятадын хилд авто замын “Цагаан дэл-Уул – Өлзий”, төмөр замын “Шивээхүрэн-Сэхэ”, Гашуунсухайт-Ганц мод”, “Бичигт-Зүүн хатавч”, “Сүмбэр-Рашаан” боомтуудыг шинээр нээхээр хоёр тал дипломат шугамаар тохиролцож, бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна.

Агаарын замын хилийн боомтын хувьд "Буянт-Ухаа" боомт 1996 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 58, "Өлгий" боомт 2003 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 51, "Чойбалсан" боомт 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 344, "Ховд" боомт 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 344 дүгээр тогтоолыг үндэслэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 344 дүгээр тогтоолоор Даланзадгад, Мөрөн агаарын замын олон улсын боомт байхаар тогтоосон боловч үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдээгүй тул нээгдээгүй. “Хөшигтийн хөндий” дэх олон улсын шинэ нисэх буудал 2021 оны 7 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Ингэснээр "Буянт-Ухаа" агаарын замын боомтыг тус нисэх буудалд шилжүүлснээр өнөөгийн хүчин чадал 2 дахин нэмэгдэж, үйл ажиллагаа нь өргөжсөн байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 24 хилийн боомт тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Дээрх хилийн боомтод

Хүснэгт 1. 2015-2019 онд улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн тоо

Он	орсон	гарсан	орон	нийт
2015	2415091	2444170	195	4859261
2016	2711919	2723348	194	5435267
2017	2964029	2984320	183	5948349
2018	3043550	3058468	184	6102018
2019	3043503	3052940	186	6096443
Нийт	14178092	14263246	Дунджаар 188	28441338

хилийн хяналтын байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагааг ихэвчлэн өөрсдийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу (зарим байнгын ажиллагаатай олон улсын зэрэглэлтэй хилийн боомтуудад ээлжийн зарчмаар явагддаг) зохион байгуулдаг.

Дэлхий дахинаа 2019 оны сүүлээс БНХАУ-ын Ухань хотод гарсан цар тахал буюу Covid-19 халдварт өвчин гарч, Монгол Улс 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хилээ хааж, хилийн боомтын үйл ажиллагааг тусгай горимд шилжүүлэн хязгаарлагдсан нөхцлөөр зарим зөвшөөрөл олгогдсон зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг нэвтрүүлээд 2022 оны эхээр улсын хилийг нээсэн. Үүнээс хойшхи улсын хил нэвтэрсэн үеийн судалгааг ашиглах боломжгүй байсан тул 2015-2019 оны хоорондох статистик тоон судалгааг ашиглав.

Хилийн 26 (2020 он хүртэл ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хэлэлцээрүүд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан үеийн ажиллаж байсан хилийн боомтууд) боомтоор 2019 оны 12 сарын байдлаар 181 орны 6.09 сая зорчигч, 90 орны 3.6 сая тээврийн хэрэгслийг¹ улсын хилээр нэвтрүүлсэн байна.


Улсын хилээр 2015-2019 онд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн тоог нэгтгэн гаргахад дараах тоон үзүүлэлт гарч байна. Хүснэгт 1, 2-оор харуулав.

¹ Үндэсний статистикийн хороо., - <https://www.1212.mn/> Статистикийн бюллетен, УГ., 2019.

Хүснэгт 2. 2015-2019 онд улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн судалгаа

Он	орсон	гарсан	Орон	Нийт
2015	1070961	1076036	112	2146997
2016	1391473	1386252	116	2777725
2017	1830204	1827355	91	3657559
2018	1857177	1852242	87	3709419
2019	1846474	1839319	95	3685793
Нийт	7996289	7981204	Дунджаар 100	15977493


2015-2019 онд улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн тоог графикчилсан байдлаар гаргахад дараах байдлаар харагдаж байна. График 1-ээр харуулав. Дээрх график тоон үзүүлэлтээс харахад зорчигчдын тоо 2015-2018 он хүртэл өсөлттэй, 2019 онд 5575-аар буурсан байна. Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн хувьд мөн адил 2015-2018 он хүртэл өссөн үзүүлэлттэй, 2019 онд 23626-аар буурсан байна. 2019 оныг эс тооцвол зорчигч, тээврийн хэрэгсэл 2015-2018 он хүртэл өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1. 2015-2019 онд улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн судалгаа

Хилийн боомтоор Короно вирусийн цар тахлаас шалтгаалж хилийн зөрчил эрс буурсан боловч боомтын үйл ажиллагаа 2022 оноос хэвийн горимдоо шилжсэн. Үүнтэй зэрэгцээд хилийн зөрчил ихсэх

хандлага ажиглагдаж байна. Гарсан зөрчлүүдийг хэлбэрээр нь авч үзвэл: Бусдын баримт бичиг ашиглах, хил нэвтрэх эрхийн баримт бичиггүй, гадаад орны цагдаа болон цагаачлалын албаны бичигтэй, ижил төстэй хүний баримт бичиг гаргуулсан, штамд дардас хуурамчаар үйлдсэн зэрэг зөрчлүүд зонхилж байна.

Мөн улсын хилээр 2023 онд давхардсан тоогоор 2981.7 мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оноос 344.4 мянгаар өсжээ. Тэдгээрийн 51.5 хувийг ачааны



машин, 34.7 хувийг ачааны вагон, 10.7 хувийг суудлын машин, 3.1 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслийн 35.6 хувь нь Замын-Үүд, 22.2 хувь нь Гашуун сухайт, 10.3 хувь

нь Шивээхүрэн, 8.1 хувь нь Сүхбаатар, 7.4 хувь нь Алтанбулаг, 16.4 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.

Үүнээс харахад хилийн Замын-Үүд, Буянт-Ухаа, Алтанбулаг, Сүхбаатар, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган зэрэг 7 боомтоор улсын хилээр нэвтрэх зорчигчдын 91 хувь нь нэвтэрдэг бол ердөө 9 хувь нь бусад 19 боомтоор улсын хил нэвтэрдэг байна.¹ гэж үйл ажиллагааны тайландаа дурджээ.

Дүгнэлт, санал

Улсын хилээр нэвтрэх тухай ойлголт нь олон улсын хэм хэмжээний акт болон бусад үндэсний хууль тогтоомжуудын хүрээнд зохицуулагддаг. Хилийн дэглэмийн агуулга, мөн чанарын хувьд хил залгаа улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, мөрдүүлэхэд чиглэгдсэн байна. Харин хилийн боомтод мөрдөх журмын гол агуулга нь хилийн боомт, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор боомт тус бүрдээ боловсруулан мөрддөг байна. Хилийн боомтын үйл ажиллагаа нь онолын түвшинд улсын хил нэвтрэх, улсын хилээр нэвтрүүлэх, хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтод мөрдөх журам, хилийн хяналт шалгалт, хилийн зөрчил, хилийн боомтын зөрчилд тооцох зэрэг асуудлын хүрээнд өөрийн гэсэн онолын үндэслэлтэй, тодорхой хууль тогтоомжийн хүрээнд баталгаажсан, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, шаардлагатай орчин бүрдсэн газарт явагдаж буй цогц ажиллагаа гэж дүгнэн үзэж байна.

Хилийн боомтын үйл ажиллагааг илүү аюулгүй, найдвартай, хурдан шуурхай илүү боловсронгуй болгосноор улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж судлаачийн зүгээс дүгнэн үзэж байгаа бөгөөд хилийн боомтын үйл ажиллагааг илүү сайжруулсанаар хилийн зөрчлийн илрүүлэлт нэмэгдэнэ гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Арвай Ш. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол, Уб., 2005.

- БНМАУ-ын хил хамгаалах тухай хууль, Уб., 1973.

- Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны тайлан, Уб., 2019.

- Доржням Ц. Улсын хил зөрчих гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага, криминологийн асуудал, Уб., 2012.

- (Жанцан.С). Монгол Улсын эрүүгийн эрх зүй (тусгай анги, схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал), Уб., 2005, 2011.

- Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2016. №28

- Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. 2004.

- Монгол Улсын Хилийн тухай хууль, Төрийн мэдээлэл, Уб., 2017, №06

- Монгол хэлний их тайлбар толь. ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн. Уб., 2015.

- Монсудар хэвлэлийн газар, Монгол хэлний тайлбар толь, нэмж

¹ ХХЕГ-аас сар бүр ҮСХ-нд хүргүүлдэг судалгаа, Уб., 2019.

засварласан хоёр дахь хэвлэл, Уб., 2018.

- Нарангэрэл С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (тусгай анги), Уб., 1998.

- Совд Г., Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, Уб., 2002.

- Үндэсний статистикийн хороо, Статистикийн бюллетен, Уб., 2019.

- Хилийн боомт болон Монгол, Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, 1994.

- “Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв” ХЗДХЯ-ны захиалгат судалгааны ажил, Уб., 2012.

- “Хилийн боомтод гарч буй зөрчил, түүнд хийсэн дүн шинжилгээ” МУ-ын Үндэсний Аюулгүй Зөвлөлийн захиалгат судалгааны ажил, Уб., 2020.

- Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын аюулгүй

байдал, шалган нэвтрүүлэх газрын тайлан, танилцуулга мэдээлэл, Уб., 2019.

- Хил хамгаалах ерөнхий газраас сар бүр Үндэсний статистикийн хороонд хүргүүлдэг судалгаа, Уб., 2019.

- Хулан Г. “Хилийн боомтод хүний аюулгүй байдлыг хангах асуудлын судалгаа”, диссертац, Уб., 2019.

- Цэвэл Я. Монгол хэлний тайлбар толь, Уб., 1966.

- Чимэд Б. БНМАУ-ын Захиргааны эрх зүйн ерөнхий ангийн үндсэн асуудал. Уб., 1973.

- “Шинжлэх ухаан, практикийн анхаарал татсан асуудлууд-2017” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2017.

- <https://mongoltoli.mn/search.php>

- <https://toli.query.mn>.

- <https://www.immigration.gov.mn/report>

- <https://www.1212.mn>